

ХҮНИЙ НӨӨЦИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ

Дотоод хэргийн их сургуулийн дэргэдэх салбар зөвлөлийн хурлыг 2023 оны оны 01 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулж, хурлаар 2022 оны ажлын тайланг танилцуулж, 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус хэлэлцэн батлуулсан.

Албан тушаал дэвшүүлэх нөөцийн саналыг бүрэлдэхүүн сургууль, бүтцийн нэгжээс авч албан тушаалын тодорхойлолт болон холбогдох хууль, тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг нягтлан удирдлагад танилцуулж Төрийн албаны зөвлөлийн Дотоод хэргийн их сургуулийн дэргэдэх Салбар зөвлөлийн даргын 2023 оны 01 дүгээр тогтоолоор Албан тушаал дэвшүүлэх нөөцийн жагсаалтыг батлуулсан.

Их сургуулийн албан тушаалд дэвшүүлэх 2021, 2022, 2023 оны нөөцийн сангаас нийт 26 албан хаагчийг дэвшүүлэн томилсон.

Төрийн албаны зөвлөлийн Дотоод хэргийн их сургуулийн дэргэдэх Салбар зөвлөлийн даргын 2023 оны 01 дүгээр тогтоолоор “Их сургуулийн албан тушаалд дэвшүүлэх нөөцийн сан”-д бүртгэгдсэн 23 албан хаагчийг албан тушаалаас чөлөөлж, дэвшүүлэн томилсон.

Төрийн албаны зөвлөлийн Дотоод хэргийн их сургуулийн салбар зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 03 дугаар тогтоолоор “Шалгалтын комисс байгуулан” төрийн албаны тусгай шалгалтыг зохион байгуулсан.

Дотоод хэргийн их сургуулийн албан хаагч, ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, хүний нөөцийн бодлогын баримт бичгийн төлөвлөгөөг тус тус батлан, хэрэгжүүлж байна.

Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар 14 хоног тутам нийт албан хаагчид мэдээлэл өгч ажиллаж байна.

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ